

# Рубикийн шоо

Эвлүүлсэн Рубикийн шоо болон үйлдлүүдийн дараалал (шооны талсуудыг эргүүлэх дараалал) өгөгдсөн. Рубикийн шоог дахин эвлүүлсэн байдалд нь оруулахын тулд өгөгдсөн үйлдлүүдийн дарааллыг хэдэн удаа хэрэглэхийг ол.

## Input

Үйлдлүүдийн дараалал нь U, D, L, R, F, B буюу харгалзан дээд, доод, зүүн, баруун, урд, ард талсыг илэрхийлэх тэмдэгтүүдээр өгөгдөх ба энэ нь уг талыг цагийн зүүний дагуу 90 градус эргүүлнэ гэсэн үг юм. Оролт дахь тэмдэгтүүд нь хоорондоо дурын тооны зай эсвэл мөр шилжүүлэх тэмдэгтүүдээр тусгаарлагдаж болно. Тестийн файлын хэмжээ 190 килобайтаас хэтрэхгүй.

## Output

Гаралт дээр өгөгдсөн үйлдлүүдийн дарааллыг хэдэн удаа хэрэглэх хэрэгтэйг заах нэг бүхэл тоо гаргана.

## Example

**Input:**

DD

**Output:**

2